



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 10 сарын 02 өдөр

Дугаар 2/688

Булган сум

Гүйцэтгэгчтэй гэрээ шууд байгуулах эрх олгох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.4. дахь заалт, 66 дугаар зүйлийн 66.1., Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.3. дахь заалт, 34 дүгээр зүйлийн 34.1.2. дахь заалт, Засгийн газрын 2021 оны “Босго үнийн шинэчлэн батлах тухай” 124 дүгээр тогтоол, аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2023 оны 08 дугаар сарын 04-ний өдрийн “Булган аймгийн 2023 оны төсөв баталсан тогтоолд өөрчлөлт оруулах тухай” XVII/01 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Булган аймгийн Хөгжимт жүжгийн театрын барилгын төсөв шинэчлэх ажлыг 14 410 440 (арван дөрвөн сая дөрвөн зуун арван мянга дөрвөн зуун дөч) төгрөгөөр “Кон инженерс” ХХК-тай гэрээ шууд байгуулах эрхийг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Ү.Бямбасүрэн)-т олгосугай.

2.Гэрээнд заагдсан ажлыг холбогдох хууль, журам, норм дүрмийн дагуу тогтоосон хугацаанд чанартай гүйцэтгэн хүлээлгэн өгөхийг “Кон инженерс” ХХК (Б.Онх)-д үүрэг болгосугай.

3.Булган аймгийн Хөгжимт жүжгийн театрын барилгын төсөв шинэчлэх ажилд чанарын болон хугацааны хяналт тогтмол тавьж хүлээн авахыг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Ү.Бямбасүрэн)-т даалгасугай.

4.Дээрх ажлын санхүүжилтийг Орон нутгийн хөгжлийн сангийн батлагдсан төсөл арга хэмжээнээс гэрээнд заасан үнийн дүнгээр санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Д.Батцогт)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

Б.АРИУН-ЭРДЭНЭ



6323010788